



# Барилгын салбар дахь миний хөдөлмөрийн гараа

Хэвлэлтийг

**giz** Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

# Ур чадварыг хөгжүүлэх



Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, ХБНГУ-ын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (ЭЗХАХЯ) ба Азийн Хөгжлийн Банк (АХБ) хамтран “Ур чадварыг хөгжүүлэх” төслийг 2019 онд эхлүүлсэн.

**АХБ болон ЭЗХАХЯ хамтран дэд бүтцийн төслүүдийн ашиглагдаагүй нөөц бололцоог, ажлын байран дээрх сургалт** зохион байгуулах замаар нээн илрүүлэх боломжтой гэсэн итгэл үнэмшилтэйгээр **стратегийн түншлэлийг** бий болгон ажиллаж байна.

Германы хосмог сургалтын системээс санаа авч МБСургалтын үйл ажиллагаа болон АХБ-ын дэд бүтцийн төслийн хүчтэй оролцоонд тулгуурлан хэрэгжиж буй “Ур чадварыг хөгжүүлэх” төсөл нь ЭЗХАХЯамны даалгавраар Германы Олон Улсын хамтын ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байна. Төслийн хүрээнд салбар болон байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлснээр, тулгамдаад байгаа ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, дадлагад суурилсан мэргэжлийн сургалтыг хэрхэн хэрэгжүүлж болдгийг харуулахыг зорьж байгаа юм.


Монгол Улс дахь “Ур чадварыг хөгжүүлэх” төсөл нь “Улаанбаатар Хотын Гэр Хорооллыг Хөгжүүлэх Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр” (ГХХХОХ) төслийн хүрээнд хэрэгжиж буй барилгын талбарт

- ажлын байран дээрх сургалт
- үйлдвэрлэлийн дадлагажуулагчийг мэргэшүүлэх сургалтуудыг дэмжин ажиллаж байна.

Мөн МБС болон Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгтгэсэн дижитал интерфейс хөгжүүлснээр нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломжтой болно.



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл GIZ-ийн “Ур чадварыг хөгжүүлэх” төслийн цахим хуудсаар болон [build4skills@giz.de](mailto:build4skills@giz.de) и-мэйлээр холбогдоорой



# Өмнөх Мэдлэг, Ур Чадварыг Хүлээн Зөвшөөрөх Үнэлгээ (RPL)

**Хэнд зориулсан бэ?** Та барилгын салбарт ажиллаж байсан боловч мэдлэг, ур чадвараа албан ёсоор үнэлүүлж байсан уу? Албан бус хэлбэрээр эзэмшсэн ур чадвараа үнэлүүлэн, гэрчилгээ авахыг хүсвэл өмнөх мэдлэг ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээнд хамрагдаарай.

**Ур Чадвараа хэрхэн үнэлүүлэх вэ?** Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Үнэлгээ, Мэдээлэл, Аргазүйн Төв (МБСҮМАТ) болон мэргэжлийн үнэлгээний ажилтантай хамтран Таны эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлэхийн тулд онолын мэдлэг болон ур чадварын түвшинг үнэлэх үнэлгээг хийнэ. Энэхүү үнэлгээнд Та өөрийн эзэмшсэн чадамж, ур чадварын түвшингүүдээс сонгон оролцох боломжтой. Үнэлгээнд тэнцсэн оролцогчид үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чадамжийн гэрчилгээ гардан авна. Харин тэнцээгүй тохиолдолд ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах боломжтой болно.

**Ямар давуу талууд үүсэх вэ?** Албан ёсны, хүлээн зөвшөөрөгдсөн Мэргэжлийн чадамжийн гэрчилгээтэй болсноор та ажлын байранд үндсэн ажилтнаар ажиллах, албан тушаалд дэвших боломжтой болно. Ажил олгогчид Чадамжийн гэрчилгээг үндэслэн Таныг юу хийж чадах, Танаас юу шаардах боломжтойгоо илүү сайн ойлгоно. Түүнээс гадна Танд ажлын байран дээрээ ур чадвараа дээшлүүлэх улмаар мэргэшлийн түвшингээ ахиулах боломж олдоно.



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл МБСҮМАТ-ийн цахим хуудсаар зочилно уу.



# Ажлын байран дээрх сургалт

**Хэнд зориулагдсан вэ?** МБСБ-ын суралцагч болон өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээнд тэнцээгүй иргэд

- Та өөрийн сонгосон мэргэжлээрээ шинэлэг, өндөр түвшний ур чадваруудыг эзэмшмээр байна уу?
- Та барилгын салбарт сонирхолтой ажлын бодит орчинд, төрөл бүрийн мэргэжилтнүүдтэй хамтран ажилламаар байна уу?
- Та Монгол Улсын барилга, хот байгуулалтын их бүтээн байгуулалтад оролцож, ирээдүйн хөгжлийн өнгө төрхийг тодорхойлоход өөрийн хувь нэмрээ оруулахыг хүсч байвал энэ сургалтад бүртгүүлнэ үү.

**Хэрхэн дадлагажих вэ?** Хэрэв Та мэргэжлээрээ\* Барилгын ПК, Техник Технологийн ПК эсвэл Герман-Монголын МСҮТөвд суралцаж байгаа бол “Ур чадварыг хөгжүүлэх” төсөл Танд АХБ-ны ГХХХОХ төслийн гэрээт компаниудын ажлын байран дээрх дадлага сургалтад хамрагдахад тань дэмжлэг үзүүлэх болно.

**Ямар давуу талууд үүсэх вэ?** Мэргэжлийн сургалтын байгууллагад эзэмшсэн чадамжаа ажлын байрны бодит орчинд ашиглах боломжийг олгоно.



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл АХБ-ны ГХХХОХ төслийн цахим хуудсаар зочилно уу.

\* бетон арматурчин, гагнуурчин, сантехникч, барилгын цахилгаанчин, барилгын засал чимэглэлчин, мужаан, барилгын өрөг усрагч



**Бидэнтэй холбогдоно уу**

Утас: +976 9964 1651

И-мэйл: [anar@tvetaclmlsp.gov.mn](mailto:anar@tvetaclmlsp.gov.mn)

# Үйлдвэрлэлийн дадлагажуулагч

**Хэнд зориулагдсан бэ?** Аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэр дээрх инженер, техникийн ажилтан

- Та өөрийн эрхэлдэг ажлын байран дээрээ ахисан түвшний ур чадварын гэрчилгээтэй, 3-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, шинэ залгамж халаагаа бэлтгэх хүсэл сонирхолтой бол.
- Тийм бол та үйлдвэрлэлийн дадлагажуулагчаар мэргэшиж, хөдөлмөрийн гараагаа эхлүүлж байгаа залууст туршлагаа хуваалцаж, зааж сургах чадвар эзэмших боломжийг бүү алдаарай.

**Хэрхэн Үйлдвэрлэлийн дадлагажуулагч болох вэ?** ХБНГУ, Австрали, БНСУ-ын Засгийн газруудын санхүүжилтээр GIZ-ийн “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” (ТСТМБС төсөл) болон “Ур чадварыг хөгжүүлэх” төслүүд хамтран Үйлдвэрлэлийн дадлагажуулагчаар мэргэшүүлэх 6 өдрийн сургалтыг зохион байгуулж байна.

Сургалтаар Танд:

- Заах, сурганы арга зүй,
- Ажлын байран дээрх сургалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулах,
- Үнэлж дүгнэх зэрэг чадваруудыг олгодог.

**Ямар давуу талууд үүсэх вэ?**

Таны зааж сургах, зохион байгуулах болон манлайлах ур чадваруудыг хөгжүүлнэ. Та байгууллагынхаа шинэ залуу ажилтнуудыг сургаж тэднийг илүү ихийг хийж бүтээхэд нь бодитоор дэмжих болно!



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл GIZ-ийн ТСТМБС төслийн цахим хуудсаар зочилно уу.



# Барилгын салбар – эрэлттэй ажил мэргэжил

Монгол Улсын албан ёсны статистик мэдээллээр 2018 онд 76,000 иргэн барилгын салбарт хөдөлмөр эрхэлсэн нь барилгын салбарыг **улсын хэмжээний 5 том ажил олгогч салбарын нэгэнд** тооцогддог.

Гэсэн хэдий ч салбарын хэрэгцээ шаардлагыг хангахын тулд аж ахуйн нэгжүүдэд нэмэлтээр 18,600 ажиллах хүч шаардлагатай байсаар байна. Энэ хэрэгцээ, шаардлага нь 2017 онтой харьцуулахад хоёр дахин нэмэгджээ. Ур чадвартай ажиллах хүчний хомсдолоос үүдэн гаднын ажилчдыг авчран ажиллуулахад хүргэж байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Газрын мэдээллээр 2019 онд Монгол Улсын барилгын салбарт 2,000 орчим гадаад ажилчдыг ажиллуулсан байна. ([www.1212.mn](http://www.1212.mn))

Улсын хэмжээнд **хамгийн их эрэлттэй 20 мэргэжлийн 5 нь барилгын салбарын мэргэжлүүд** багтаж байна. Тухайлбал: бетон арматурчин, барилгын мужаан, дотоод засал чимэглэл, барилгын цахилгаанчин, гагнуурчин, сантехникч, барилгын өрөг угсрагч зэрэг мэргэжлүүд хамгийн их эрэлттэй байна.



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл [www.mergejil.mn](http://www.mergejil.mn) цахим хуудсаар зочилно уу.



Federal Ministry  
for Economic Cooperation  
and Development



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH



Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)  
Бонн болон Эшборн хотуудад байрлах төв оффисууд

Фридрих-Эберт-Аллее 32+36  
53113 Бонн, Герман Улс  
Утас +49 228 4460- 0  
Факс +49 228 4460- 17 66

Даг-Хаммарскөлд Вег 1-5  
65760 Эшборн, Герман Улс  
Утас +49 6196 79- 0  
Факс +49 6196 79 – 1115

Емайл [info@giz.de](mailto:info@giz.de)  
Вебсайт [www.giz.de](http://www.giz.de)